



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар A/438

Сүхбаатар сум

### “Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ” хөдөлгөөн өрнүүлж, үр дүнг тооцох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288-р тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.17, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1. дэх зорилт, Аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмж, ёс зүй, харилцааны соёл, үйлчилгээний шуурхай байдлыг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт төр, төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад “Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ 2017-2020” хөдөлгөөнийг өрнүүлсүгэй.

2. “Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ 2017-2020” хөдөлгөөний удирдамжийг 1 дүгээр, төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хөдөлгөөнийг удирдамж, төлөвлөөгөөний дагуу сум орон нутаг, байгууллагын хэмжээндээ өрнүүлж, үр дүнг тооцож ажиллахыг сумдын Засаг дарга, тосгоны захирагч, байгууллагын удирдлагуудад, хэрэгжүүлэх ажлын явц үр дүн, тэргүүн туршлагуудын талаар иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Лувсандаагва/-д тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д үүрэг болгосугай.



Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны  
10-р сарын 27-ний өдрийн 14:30 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**“Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ 2017-2020”  
хөдөлгөөний удирдамж**

**Нэг.Хэрэгцээ, шаардлага:**

2016 оны жилийн эцсийн төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангаар аймгийн хэмжээнд нийт 198 төр, төсвийн байгууллагын 5044 төрийн албан хаагч ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

2017 оны эхний 8 сарын байдаар аймгийн санал, өргөдөл, гомдлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд аймгийн Засаг даргын нэр дээр болон 70361111 шууд утсаар 24, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 8, нийт 32 төрийн албан хаагч, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол гарсан нь нийт өргөдөл гомдлын тодорхой хувийг эзэлж байна.

Сэлэнгэ аймгийн хувьд төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 онд “Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил”, 2015 онд “Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйг эрхэмлэх жил”, 2016 онд “Ил тод байдлыг хангах ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, зарласан жилийн хүрээнд олон талт ажил арга хэмжээг зохион байгуулсан нь тодорхой үр дүнд хүрч байсан.

Гэвч төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, ёс зүй, харилцаа, хүнд суртлын талаар иргэдээс санал гомдол буурахгүй, энэхүү доголдол дахин давтагдсаар байгаад дүгнэлт хийж, аймгийн хэмжээнд нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, төрийн үйлчилгээнд соёлтой харилцаа, шуурхай үйлчилгээг бэхжүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

**Хоёр.Зорилго:**

Төрийн албан хаагчдын мэдлэг, харилцааны ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах замаар аймгийн нийт төр, төсвийн байгууллагуудад хэрэглэгч төвтэй үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг хангах зорилгоор энэхүү хөдөлгөөнийг өрнүүлэхэд оршино.

**Гурав.Арга хэмжээ:**

Дээрх зорилгын хүрээнд дараах бүлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.Хүний нөөцийн болон албан хаагчдын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэх

3.2.Харилцааны ур чадварыг сайжруулж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах

3.3.Үйлчилгээний стандартыг мөрдүүлж, цаг хугацааны сахилга батыг баримтлах

3.4.Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг тогтмолжуулах

3.5.Иргэд, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэн соёлтой харилцаж шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг ханган, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

**3.6.Үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх, иргэдийн гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн эргэн хариу мэдэгдэх ажлыг зохион байгуулах**

**Дөрөв.Хугацаа:**

2017-2020 онд хэрэгжүүлнэ.

**Тав.Хамрах хүрээ:**

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төр, төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, төрийн үйлчилгээний байгууллагуудад хэрэгжүүлнэ.

**Зургаа.Шалгуур үзүүлэлт:**

Төрийн ажил үйлчилгээ, албан хаагчдын үйл ажиллагааны чанар үр дүнд хамаарах дараах шалгуур үзүүлэлтээр “Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ” хөдөлгөөний үр дүнг жил бүр үнэлнэ. Үүнд:

-Албан хаагчдын ажлын үр дүнгийн үнэлгээ

-Богино хугацааны төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтанд хамрагдалтын хувь

-Ёс зүйн зөрчлийн гаралт, бууралт

-Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой СӨГ-ын гаралт, бууралт

-Хэрэглэгчийн үнэлгээний өсөлт, бууралт

**Долоо.Хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

“Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ” хөдөлгөөний хэрэгжилт үр дүнд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ.

Шаардлагатай тохиолдолд зарим байгууллагад явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож болно.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны  
10-р сарын 27-ний өдрийн 14:30 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**“СОЁЛТОЙ ХАРИЛЦАА-ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ 2017-2020” ХӨДӨЛГӨӨНИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Арга хэмжээ	Хугацаа	Үр дүн	Хэрэгжүүлэгч байгууллага
<b>Нэг. Хүний нөөцийн болон албан хаагчдын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэх</b>			
Төрийн албаны стандартын хэрэгжилтийг орон нутагт хангах үйл ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудад нэгдсэн үзлэг, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллах	2017 оны 4-р улиралд	Төрийн албаны стандартын хэрэгжилт хангагдана.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Аймгийн ЗДТГ
Байгууллагын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулах арга хэмжээ авч ажиллах	2017-2020 онд	Хүний нөөцийн бодлого тодорхойлогдож, хэрэгжинэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Төрийн жинхэнэ болон удирдах албан тушаалын сул орон тооны захиалгыг холбогдох дүрэм журмын дагуу тухай бүр аймгийн ТАЗСЗ-д ирүүлэх	2017-2020 онд	Ажлын байрны захиалгын дагуу ТАМШ болон удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлагдаж, сул орон тоонд шаардлага хангасан хүн томилогдох нөхцөл бүрдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд
Төрийн жинхэнэ болон удирдах албан тушаалын сул орон тооны захиалгын дагуу	2017-2020 онд	Сонгон шалгаруулалт хийгдэж, сул орон тоо	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл,

	ТАМШ болон Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтыг ТАЗ-тэй хамтран тухай бүр зохион байгуулах		журмын дагуу нөхөгдөнө.	Аймгийн ЗДТГ
	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын боловсруулалт, хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	2018 онд	Хөдөлмөрийн дотоод журам хууль тогтоомжид нийцсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөлтийг жил, улирлаар баталж, үр дүнг тооцож ажиллах	2017-2020 онд	Ажлын үр дүн тооцогдож, бүтээмж нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг ТАЗ-өөс баталсан журам, загварын дагуу боловсруулах, тайлагнах, үнэлж дүгнэх	2017-2020 онд	Журмын хэрэгжилт хангагдана.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Албан хэргийн боловсруулалт, хариутай албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээний шалгуур үзүүлэлтэнд тооцдог болох	2017-2020 онд	Албан хэргийн боловсруулалт, хариутай албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллагууд
	Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлт, баяжилтанд хяналт тавьж, жигдрүүлэх арга хэмжээ авах	2017-2020 онд	Хувийн хэргийн бүрдэл, хөтлөлт сайжирна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	“Ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тооцож, түүний мөрөөр тодорхой арга хэмжээг зохион байгуулах	2017-2020 онд	Албан даалгаврын хэрэгжилт тогтмолжино.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, иргэд, хэрэглэгчдэд сурталчлах, таниулах арга хэмжээ авах	2017-2020 онд	Иргэд, хэрэглэгчид шаардлагатай зарим үйлчилгээг цахимаар хүртэх боломжтой болно.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллагууд

**Хоёр.Харилцааны ур чадварыг сайжруулж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах**

Ёс зүйн хэм хэмжээний холбогдолтой эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуйж, ёс зүйн зөрчилгүй ажиллах	2017-2020 онд	Ёс зүйн зөрчилгүй ажиллана.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Аймаг, сум, байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын төлөвлөгөө гаргаж, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллах	2017-2020 онд	Ёс зүйн хорооны үйл ажиллагаа эрчимжинэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Албан хаагчдын зан харилцаа, ёс зүйн асуудлаар иргэдээс санал асуулга авч, үр дүнг тооцон холбогдох арга хэмжээг авч ажиллах	2017-2020 онд	Ёс зүйн зөрчилгүй ажиллана.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Ажлын байрны дотоод эмх цэгц, төрийн албан хаагчийн хувцаслалт, харилцааны соёл, ёс зүйн асуудалд анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах	2017-2020 онд	Байгууллагын соёл бэхжинэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Авлига, ашиг сохиরхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох	2018-2020 онд	Авлига, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллана.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ

**Гурав.Үйлчилгээний стандартыг мөрдүүлж, цаг хугацааны сахилга батыг баримтлах**

Албан хаагчдын ажлын цаг бүртгэлийг цахимжуулж, хяналт тавьж ажиллах	2017-2020 онд	Ажлын цаг хоцрогдолгүй болно.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгч тэвтэй үйлчилгээг хэвшүүлж, угтах үйлчилгээг хэрэгжүүлэх	2017-2020 онд	Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
Ажилтнуудын дунд “Хөдөлмөрийн сахилга бат, бүтээмжийг дээшлүүлэх” талаар шинэ санаа, шинэлэг арга барил, бүтээлийн	2018-2020 онд	Шинэ санал, санаачлага бий болно.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ

	уралдаан зохион байгуулж, үр дүнг тооцох			
	Сахилга, дэг журам, хүмүүсийн хоорондын харилцааны талаар эрдэмтэн, мэргэдийн болон ардын зан заншил, сургаал, онч мэргэн үгсийг ажлын байран дээр байрлуулах, шинэчлэх, албан хаагчдад түгээх	2017-2020 онд	Албан хаагчдад шинэ мэдлэг нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	СӨГ-ын хуулийн хугацаанд шийдвэрлэх, боломжтой асуудлуудыг тухай бүр шийдвэрлэж, хариуг СӨГ гаргагч иргэн, байгууллагад албан ёсоор хүргүүлж ажиллах	2017-2020 онд	СӨГ хугацаандаа шийдвэрлэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, байгууллагын албан ёсны цахим хуудас/web site, facebook гэх мэт/-ны баяжилтыг тухай бүр хийх	2017-2020 онд	Иргэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүртэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Иргэдийн СӨГ-ыг техник технологийн дэвшлийг ашиглан сошиал бүхий л хэлбэрээр авч, шуурхай шийдвэрлэж ажиллах	2017-2020 онд	Иргэд байгууллагын харилцаанд ахиц гарна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ

**Дөрөв. Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг тогтмолжуулах**

	Байгууллагын сургалтын хөтөлбөрийг албан хаагчдын сургалтын хэрэгцээг үндэслэн боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	2018-2020 онд	Сургалтын бодлогын баримт бичигтэй болсон байна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Жил бүр сургалтын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	2018-2020 онд	Албан хаагчид хэрэгцээт сургалтанд хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Хувь хүний хөгжлийг дэмжих бодлого баримталж, хэрэгцээт сургалтыг	2018-2020 онд	Албан хаагчид хэрэгцээт сургалтанд хамрагдаж,	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн

	мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах		мэдлэг дээшлүүлнэ.	чадвараа байгууллага, ОНӨААТҮГ
	Дотоод нөөц бололцоонд тулгуурлан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж, хэвшүүлэх	2018-2020 онд	Албан хаагчдад ажлын байран дээрээ хөгжих нөхцөл бүрдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Шаардлага хангасан төрийн албан хаагчид, иргэдийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн элсэлтийн шалгалтанд оролцуулж, мэргэшүүлэх сургалтанд хамруулах	2017-2020 онд	Төрийн албан хаагчид удирдлагын арга зүйгээр мэргэшсэн байна.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллагууд
	Албан хаагчдын дунд мэрэшлийн болон ерөнхий мэдлэг, танин мэдэхүйн холбогдолтой болзolt уралдаан, тэмцээн/илтгэл, эссэ, шинэ санаа гэх мэт-/ийг зохион байгуулж, урамшуулж ажиллах	2018-2020 онд	Албан хаагчдын дунд өрсөлдөөн бий болж, мэдлэг чадвар нэмэгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллагууд

**Тав.Иргэд, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх**

	Байгууллагын дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлж, дотоод хяналтын албан хаагч, нэгжийг томилгоожуулан ажиллуулах	2018-2020 онд	Дотоод хяналтын ажилтантай болно.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Байгууллагын болон нэгж, албан хаагчийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллах	2018-2020 онд	Дотоод хяналтын үйл ажиллагаа хэрэгжинэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Иргэд, хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх боломж нөхцөлийг судалж, хэрэгжүүлэх	2017-2020 онд	Хэрэглэгчийн үнэлгээ хийгдэнэ.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ
	Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр ажил үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	2017-2020 онд	Хэрэлэгчийн үнэлгээний үр дүн тооцогдоно.	Аймаг, сумын ЗДТГ, агентлаг, төр, төсвийн байгууллага, ОНӨААТҮГ

**Зургаа.Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр**

Захирамжийн хэрэгжилтийг эхлүүлж, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авах	2017 оны 4-р улиралд	Шийдвэрийг олон нийтэд таниулж, хэрэгжүүлж эхэлнэ.	Аймгийн ЗДТГ
Хөдөлгөөнийг өрнүүлэх тухай самбарын загвар гаргаж, байгууллагуудад байршуулах ажлыг зохион байгуулах	2017 оны 4-р улиралд	Шийдвэрийг олон нийтэд таниулж, хэрэгжүүлж эхэлнэ.	Аймгийн ЗДТГ
Хөдөлгөөний зорилго, зорилтод нийцүүлэн ТАЗСЗ-ийн уриаг жил бүр зарлаж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах	2018-2020 онд	Хөдөлгөөний хэрэгжилт эрчимжинэ.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Аймгийн ЗДТГ
Төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэж, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	2018-2020 онд	Хэрэгжилт, явц үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэгдэнэ.	Аймгийн ЗДТГ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**